



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ТАТВАРЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 04 сарын 06 өдөр

Дугаар 4/19

Арвайхээр

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Татварын хэлтсийн даргын 2022 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн Б/08 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Өвөрхангай аймгийн Тарагт сумын татварын улсын байцаагч Ж.Амарбаясгалангийн ажлыг хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнээр байгуулсугай.

Комиссын дарга: А.Ганчимэг (Захиргаа, хуулийн тасгийн дарга)


Гишүүд: Ц.Цэнд-Аюуш (Бичил татвар төлөгчтэй харилцах тасгийн дарга)

С.Отгонлхагва (Нягтлан бодогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Х.Түвшин (Сүлжээний инженер, нярав)

Д.Отгонтуяа (Архив бичиг хэргийн эрхлэгч)

2. Ж.Амарбаясгалангийн албан тушаалын тодорхойлолт, ажил үүргийн хуваарийн дагуу хариуцсан ажилтай холбоотой бичиг баримтыг цаасаар болон файлаар, бусад хариуцсан эд хогшилыг бүрэн хүлээлцэхийг Захиргаа, хуулийн тасгийн дарга (А.Ганчимэг)-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Н.ЭРДЭНЭСУВД



621001037